



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/566

Арвайхээр


**Тендерийг хүчингүй болгож, шууд гэрээ
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 102 дугаар дүгнэлтийн дагуу Багийн хөгжил, төрийн үйлчилгээ төсөл /Өвөрхангай, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Уянга, Хархорин, Хужирт сум/ ажлын 1 дүгээр багц Багийн эмч нарыг унаажуулах /Зүүнбаян-Улаан/ 4 дүгээр багц Багийн төвийн барилгын засвар, өргөтгөл /Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин, Уянга/, 5 дугаар багц Багийн хүний нөөцийн чадавхийг сайжруулах /Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин/ ажлуудад шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх хүчингүй болсон багцуудад шууд гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101032